

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гомбын Содов	Дугаар	L052
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Булган сум
Төрсөн газар	Дорнод аймгийн Булган сум	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Тугийн сүм	Сүм хийдийн дугаар	ДОБГ 003
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 24	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Булган сумын Тугийн сүм

Танай нутаг оронд ямар ямар сүм хийд байв?

Саруулын, Ачитын, Зүүн, Тугийн, Гүний гээд байсан. Бар хот гэдэг чинь 1000 гаруй жилийн түүхтэй. Аймаг, улсын хэмжээний дурсгалт газар . Одоо сэргээж аялал жуулчлалын газар болгох гээд байгаа юм шиг байна. Гүний хийд гэдэг чинь голын урд байсан. Гүн ноёны байгуулсан хийд. Гэгээний хийд гэж байсан. Ялгуулсны хийд гэж байсан. Ачтын хошууны олон ламтай хийд байсан. Тэр хийд байсан газар одоо аймаг байгуулагдсан. Булган сумын дээхнэ талд Түвдэнийн овоо гэж байдаг юм. Тэнд хэдэн төвд нар овоо тахиад ном уншаг байсан гэдэг юм.

-Нүгнийн хийд гэж ямар хийд байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энэ яахав ээ. Хэдхэн лам нартай зүгээр хөдөөгүүр энүүхэн манай сумын баруухантай байсан. Энэ эрт байхгүй болсон байх. Би мэдэхгүй.

-Тугийн хийдийн талаар та юу мэдэх вэ?

Чингисийн тахиж байсан хар туг нь энд байсан. Сүм дотор Чингисийн баримал, 9 баатар, нэг авхайтай (баримал) байсан. Дандаа цаасан баримал байсан. Байлдаж эзэлж авсан 4 гүрний хаан хоёр хатавчинд нь амьгүйж байгаа болтой дутуу сөгдсөн байдаг байсан. Тэнд Чингистэй нийлээд 15 хүний баримал байсан нэг тийм сүм байсан.

-Тугийн хийд хэзээ байгуулагдсан бэ?

Нэлээд хожуу. Анх байгуулагдахад Саруулын хийдээс 8 лам, Зүүн хийдээс 8 лам нийт 16 ламтайгаар хурал хүрж эхэлсэн юм гэнэ лээ. Сүүлдээ дотроосоо хүүхэд багачууд нь лам болоод. Ламын нийт тоо нь 50, 60-аас хэтрээгүй газар.

-Хурал номын талаар?

Энд бол ердөө цөөхөн. Өөрийн тугийн тахилга гээд цөөхөн зүйл уншина. Бодвол Цогчэн хүрж байсан байх. Тэгээд цаг цагийн хурал хүрж байсан. Зүнд нь тахилга тайлга гэж нэг тийм юм болдог байсан. Хурал хурад овоогоо тахиад бөх барилдаж хэдэн морь уралддаг байсан.

-Хэдэн онд байгуулагдсан юм бол?

Тэрийг 140, 150 жил болж байгаа гэж хэлдэг. Манай сумын түүхэн номд Гүрбямба тэгж бичсэн гэсэн. Зарим нь ч тэрнээс арай хол гэдэг. Яг нарийн мэдэхгүй. Туг чинь харин их баян жастай байсан юм гэдэг. Тэр нь яагаад тийм болсон юм гэхээр хандиваар их мал цугласан юм гэсэн. Хошуу бүрээс их олон мал ирсэн. Сэцэн хан аймгийн бүх хошуудаас цугласан. Энэ дуганыг Захын То ван бариулсан гэж хэлдэг. Тэгэхээр нээрээ ч 100 гарангаас хэтрээгүй болов уу гэж боддог юм. Миний ээжийн ээж 70 гаран настайдаа, миний ээж 70 гарантайдаа нас барсан юм. Би одоо нэг 80 гаран настай. Ингэхлээр 100 гаран нь ортой болж байгаа юм. Манай хөгшин эжий эд нар ярьдаг байсан юм. Энийг анх монгол хятад нийлсэн баахан хүмүүс Чингисийн тугийг тахиж сүмийг хаа байгуулах вэ гээд газар үзэж явсан. Тэгсэн нэг хурга хариулсан хүүхэд явж байсан. Нэрийг нь хэн гэдэг вэ гэж асуусан Баян эрхт гэдэг гэсэн. Энэ их сайхан нэртэй хүүхэд таарлаа гээд тэр толгой дээр чавга тавьчихаад явсан. Тэгээд баахан монгол хятад нийлсэн хүмүүс ирээд туйпуу цохиж эхэлсэн. Тэгээд баахан туйпуу цохиж цохиж сүм хийдээ барьж эхэлсэн гэж ярьдаг юм.

-Тэнд яг хэдэн сүм дуган байсан бэ?

Тугийн орой дээр байсан сүмд 15 баримал байсан. Хэлбэр нь дөрвөлжин дээрээ нэг жаахан давхартай. Давхарт гарахад доорх байшингаасаа нь өгсөж гардаг байсан. Тэрний орой дээр Чингисийн туг байсан.

Толгойн энгэрт зүүн урд дороо, их гоё нэг дуган байсан Бас нэг гэр дуган байсан.

-Хэдэн онд хаагдсан?

1937, 38 онд лам нарыг нь бариад, баригдаагүй нэг нь тараад явчихсан. 1939 онд буулгаад. Тэр олон баримлууд нь хаалгаар багтаж гарахгүй нүхэнд хийж булсан гэдэг. Тэгээд сүүлд тэнд улсын худалдаа гэдгийг бй

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

болгоод доод сүмд нь дэлгүүр гаргаад, дээд Чингисийн байсанд нь түүхий эдийн склад хийгээд байж байсан. Тэгээд сүүлд нь үрэн таран болсон. 1940 хэдэн онд буулгаад малын хашаа энэ тэр хийж бүрэн буулгаж дууссан байсан.

-Тугийн миндагтан лам нараас нэрлэнэ үү?

Бас ганц нэгийг гадарлана. Лам унзад хоёр баригдсан. Ёндон лам гэж байсан баригдсан.Хамгийн том лам нь байсан. Чойндон унзад баригдсан. Тэгээд бүр сүүлд нь сүм дуганаа эзгүй орхиод яахав гээд нэг ядуухан лам гэсгүй болоод байсан. Чойёон гээд . Тэр бас баригдсан зайлуул. Ер томхон лам нар аль ч хийдийн буцаж ирээгүй юм даа.

-Та өөрөө хийдэд шавилан сууж байсан уу?

Сууж байсан гэж ярих нэг их юм байхгүй. Сүм хийдийн хурлыг эхлүүлэх шашны номын сургуулийн сурагч байсан. 7 настайгаасаа эхэлж төвд ном заалгаад 9 настайдаа сахил аваад тэгээд хуралд яахав хүүхэд оролцож байсан.

-Та аль хийдэд хүрж байсан бэ?

Саруулын хийд гэж баруун хойд байдаг хийдэд.

-Та тэнд юу судалж байв?

Төвд цагаан толгой, хурлын уншлага,ойр зуурын Итгэл зэргийг сурч байсан. Том хурлын уншлага номонд дөхөж чадаагүй хүн. Одоо тэгээд тэр тоглож наадаж байсан хүмүүсээс ганцаараа үлдчихээд байна. Сумандаа хамгийн өндөр настай эрэгтэй хүн болчоод байна. Манай багш нас барахын өмнө дуудаад надад Саруулын хийдийн уншлага хурал номын горим дүрмийн тийм нэг номыг шашин нэг сэргэнэ. Энийг хэзээ хэрэгтэй газарт нь өгөөрэй гэсэн. Тэгээд би тэр номоо аймгийн Зүүн хийд сэргэхэд Балдандорж ламд өгсөн.

-Саруулын хийд хэр олон дугантай, хэдэн ламтай, хийд байсан бэ?

Манба дацан, Ламрин дацан гэсэн 2 дацантай. Сүм хийд 2,3 байсан. Гол сүм нь ганц том модон дуган байсан. Миний мэдэхэд 300-аад ламтай. Арай тэрнээс урд 400 хүрч байсан байх гэж бидний дээд улсууд тэгж ярьж байсан.

Саруул гүний хийдийн сахиус?

Жамсран сахиустай байсан.

-Саруул гүний миндагтангуудын нэр?

Цогчэн лам Дамбий гавж, Жамбал,Цагаанхайдав, Данзанпэрэнлэй гэж унзaduуд байсан.Хийдийн том лам Дамбий гавж, Жамбал унзад хоёр 10,10 жилээр таслагдаад явсан. Харин хоёулаа хугацаагаа дуусгачихаад ирсэн шүү. Гэсгүй нь сүүлд Чойнзон гэдэг хүн байсан. Ер нь сүүлд нь эгээ эзэнгүй хаяхаар гээд лам нэртэй ядруухан юманд түлхүүрээ үлдээгээд баригдаад юм уу, зайлаад явсан. Тэгээд нэг гэсгүй нэртэй ядруухан юм хийд орноо сахиж үлдээд яланд хамаарагдаад явж л байсан юм.

-Манба, Ламрин хоёр дацангийн миндагтануудыг санаж байна уу?

Тэрийг мэдэхгүй .

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Ямаршуу хурал ном хурдаг газар байсан бол?

Хурал бол давгүй их хурал байсан. 10 хангал, улаан шунхан Ганжууртай байсан. Хайлан хурна. Хуучин хурал гээд цагаан сарын урд 26-аас эхлээд битүүн хүртэл хурдаг. Тэгээд хамгийн сүүлд Битүүний шөнө Цэдор Лхамаа хураад маргааш өглөө нь шинэлдэг байсан.

-Майдар цам байсан уу?

Байсан. Зундаа Майдар эргэдэг. Цөөхөн цам гардаг байсан.Энэ Зүүн хийд их том цамтай байсан гэсэн. Би тэнд нь очиж байгаагүй.

-Саруул гүний хийд хэдэн онд байгуулагдсан бэ?

Саруул гүний хийд гэдэг чинь нэлээд дээхнэ юм байх аа. Лав 300, 400 жилийн түүхтэй эд байх. Тэрнээс нэг их цааш байж чадахгүй. Саруулын хийд Сан бэйс, Ачит бэйсийнхтэйгээ цуг байсан ийм учиртай юм гэнэлээ. Ингэхлээр зэрэг Ачит ноён хоёр хүүтэй байж байгаад том хүүгээ гэрлээд гарахлаар баруун талаасаа хэсэг айл тасдаж өгөөд Саруул гэдэг ноён болгосон түүхтэй юм гэнэлээ. Ингэж анх Саруулын хошуу гэж манай хошуу үүсч бий болсон учиртай. Тэр үеэс л хийд бий болсон.

-Хийд хаагдаж нураагдах үеийн тухай?

Намайг 13,14 байхад 1937 онд энэ сүм хийдийн чинь дээд лам нарыг нь бариад аваад явчихсан. Бид ч яахав сургуулийн хүүхэд болохоор гэр гэрээдээ явчихсан. Бидний дээдэх арай залуучууд нь хар болоод. Энэ Ачитын хийд ч өөрцгүй, энэ зүүн хийд ч өөрцгүй баруун хийд ч өөрцгүй 37, 38 оны үед байхгүй болцгоосон юм шүү дээ.